

**БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**

**БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН 22 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД  
ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

**2019 ОН**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцгчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцгч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцгч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцгчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцгчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцгчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**ТОӨЗ-НЫ  
ХОЛБОГДОХ ЗААЛТ**

**Шалгүүр үзүүлэлт**

ТОӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 2017, 2018 оны санхүүгийн тайлангын аудитын дүгнэлтийг ирүүлэх.</li> <li>2. Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр хийж гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, акт, фото зураг/;</li> <li>3. Ижил төстэй ажлыг сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ жил тус бүр 100 сая төгрөгөөс багагүй төсөвтэй ажил хийж гүйцэтгэсэн байх</li> <li>3 Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ борлуулалтын орлого нь тус бүр 100 сая төгрөгөөс багагүй байна.</li> <li>4 Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийнхээ 100 хувиас багагүй байна. <ul style="list-style-type: none"> <li>• Үл хөдлөх хөрөнгийн болон бусад хөрөнгийн баталгаажсан гэрчилгээ /Үнэлгээний эрх бүхий байгууллагаар үнэлэгдсэн байх, Үл хөдлөх хөрөнгийн барьцаанд байгаа эсэх талаарх, Эд хөрөнгийн бүртгэлийн газраас гаргасан лавлагаа, барьцаанд тавихыг зөвшөөрсөн албан мэдэгдэл/</li> <li>• Арилжааны банкны зээлийн тодорхойлолт /Хадгаламж зээлийн хоршоо болон Банк бус санхүүгийн байгууллагын тодорхойлолтыг тооцохгүй/</li> </ul> </li> <li>5 Улсын бүртгэлийн гэрчилгээг эхээс хуулбарлан нотариатаар баталгаажуулсан байх /тендер зарласан хугацаанаас хойш/</li> <li>6 Татварын цахим тайлангийн системээс авсан цахим тодорхойлолт /Татварын өр төлбөргүй байх/</li> <li>7 Харилцагч банкнаас өр авлагын талаарх тодорхойлолт</li> <li>8 Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт /тендер зарласан хугацаанаас хойш тус албан д хандаж авсан байна./</li> <li>9 Тендерт оролцогч нь хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүй мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгэр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.</li> <li>10 Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлэх.</li> <li>11 Үнийн саналд татвар, даатгал, бараа хүргэгдэж ирүүлэх тээврийн зардал бүгд багтсан байна./үнийн саналыг маягтын дагуу ирүүлнэ/</li> <li>12 Захиалагч татвар болон харилцагч банкнаас тендерт оролцогчийн талаар тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх.</li> <li>13 Тендерт оролцогчийг төлөөлөн гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу нотариатаар баталгаажуулан ирүүлэх.</li> <li>14 Бараа нийлүүлэлтийн үнийн хувиар, нийлүүлэх барааны фото зураг техникийн тодорхойлолт ирүүлэх</li> <li>15 Захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолтын зүйл заалт бүрийг хангасан эсэх талаарх техникийн тодорхойлолтыг ирүүлэх.</li> </ol>
----------	---

	<p>16 Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан барааг нийлүүлэн хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>17 Эхээс хуулбар хувь хийсэн материалууд нь чанарын шаардлага хангахуйц тод гаргацтай харагдахуйц хуулбарласан байх</p> <p>18 Одоо хэрэгжиж байгаа ижил төстэй ажил гүйцэтгэж байгаа бол хэрэгжилтийн талаар захиалагч байгууллагын тодорхойлолтыг ирүүлэх</p> <p>19 Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/-т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>20 Хуулбар хувь Шаардлагагүй /цахим тендер/</p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгууллагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалыа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэр /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100MB-с ихгүй, нэг файлын хэмжээ 15MB-с ихгүй байна.</p> <p>Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 13 хороо, Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>1 давхар 121 тоот</b></p> <p>Огноо: <b>2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 00 минут</b></p> <p><b>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn-ийн">www.tender.gov.mn-ийн</a> серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</b></p> <p><b>Тендер хүлээн авах хугацаанаас омно илгээсэн тендерийн материалыг буцаан авах, засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй</b></p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 13 хороо, Засаг даргын Тамгын газрын байр</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>1 давхар 121 тоот</b></p> <p>Огноо: <b>2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 15 минут</b></p>
<b>ТОӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Баянзүрх дүүргийн 22 дугаар цэцэрлэгийн алба хэрэгцээнд шаардлагатай тоног тохөөрөмж нийлүүлэх ажил, БЗДХААА/201912070</b></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Барааны нэр,	Хүчин чадал	Үйлдвэрлэсэн огноо	Нийлүүлэх хугацаа	Баталгаат хугацаа	Тоо хэмжээ
1	Хөргөгч	800 л 4 хаалгатай 900л багтаамжтай 220в-4.5квт урт 1200*700*2000	2018	Ажлын 3 хоног	24 сар	1
2	Хөлдөөгч	850 л 220в-1.8квт 2000*700*850	2018	Ажлын 3 хоног	06 сар	1
3	Хөлдөөгч	350 л 220.-1.3квт 1000-700*850	2019	Ажлын 3 хоног	18 сар	2
4	Будаа агшаагч	Багтаамж тол / 100 аяга Халуунаа хадгалдаг Эхлэх цагийг хойшнуулдаг горимтой Цэвэрлэхэд хялбар гадаргуутай 2750 Ватт чадалтай Жин 14,7 кг	2019	Ажлын 3 хоног	12 сар	1
5	Ус буцалгагч	35л 220в-2квт	2018	Ажлын 3 хоног	6 сар	1
6	Аяга ариуттагч	1200л /2 хаалгатай/ 220в-1.8квт 1200*500*1600	2019	Ажлын 3 хоног	12 сар	1
7	Суурин компьютер	Үйлдлийн систем : <b>Windows 10 Home (64bit)</b> Процессор: 8th Generation Intel® Core™ i5-8265U Processor 3.1Ghz Шуурхай санах ой : 8GB, 2666MHz, DDR4 Дэлгэц: 21.5-inch FHD (1920 x 1080) IPS Anti-Glare LEDTouch Display График: Intel® UHD Graphics 620 Багтаамж : 1TB 5400 rpm 2.5" SATA Hard Drive CD/DVD уншигч: Tray load DVD Drive Интерфэйс: 1 HDMI v1.4b2 USB 3.1 Gen 11 USB 2.0 Media Card Reader: 1 3-in-1 SD Media Card Reader Audio and Speaker: 2 tuned speakers with Waves MaxxAudio Камер / Микрофон: widescreen HD (720p) Webcam Утасгүй сүлжээ: 802.11ac + Bluetooth 4.2 Баталгаат хугацаа 24 сар	2019	Ажлын 3 хоног	6 сар	2
8	Зөөврийн компьютер	Үйлдлийн систем : <b>Windows 10 Home (64bit)</b> Процессор: 8th Gen Intel® Core™ i7-8565U Processor (8MB Cache, up to 4.6 GHz) Шуурхай санах ой : 8GB, 2666MHz, DDR4; up to 16GB Дэлгэц: 15.6-inch FHD (1920 x 1080) Anti-Glare LED-Backlit Non-touch Display График: AMD Radeon™ 520 Graphics 2GB GDDR5 Багтаамж : 2TB 5400 rpm 2.5" SATA Hard Drive CD/DVD уншигч: Tray load DVD Drive Интерфэйс: 1 HDMI v1.4b2 USB 3.1 Gen 11 USB 2.0 Gen 11 Noble lock slot Media Card Reader: 1 3-in-1 SD Media Card Reader Audio and Speaker: 2 tuned speakers with Waves MaxxAudio Камер / Микрофон: widescreen HD (720p) Webcam Утасгүй сүлжээ: 802.11ac + Bluetooth 4.2, Dual Band 2.4 Баталгаат хугацаа 24 сар	2019	Ажлын 3 хоног	6 сар	2
9	3-н үйлдэлт принтер	Функци: Хэвлэх, хувилах, сканнер Хэвлэх хурд: 20 хуудас хүртэл (хар) Хэвлэх, хувилах нягтрал: 1200 x 1200dpi Сканнер нягтрал: 1200 x 1200dpi Дэлгэц: 2-Line LCD Санах Ой: 128MB Холболтууд: Hi-Speed USB 2.0 Тохиорх хор: Samsung D111S дунджаар 1000 A4 хуудас* Хэмжээ: 254 x 420 x 379мм Жин: 6.8кг Баталгаат хугацаа 06 сар	2018	Ажлын 3 хоног	6 сар	4
10	Өнгөт принтер	Хэвлэх, хувилах, сканнер Хэвлэлт: On-demand ink jet 4-colour Хэвлэх нягтрал /max/: 5760x1440 dpi Хэвлэх хурд: А4 текст (драфт) дунджаар 33/15ppm (хар/өнгөт) Фото (default) - 10x15cm/4x6" дунджаар 69 сек (хүрээтэй) Хувилах Үргэлжлүүлэн хувилах: 20 Ихэсгэж багасгах: 25-400%, Auto Fit Function Сканнердах Нягтрал: 600 dpi x 1,200 dpi	2018	Ажлын 3 хоног	байхгүй	2

11	Зөөврийн компьютер	Процессор/CPU: Intel core i3 7020U Процессорын цөм/Core /Turbo/: 2.3Ghz Шуурхай санах ой/RAM: 4GB График карт/Graphic Card: Intel HD Хатуу дискны багтаамж/HDD: 1TB Дэлгэцийн хэмжээ/Display size: 15.6 HD Үйлдлийн систем/OS: Windows 10 Home Тогтуулагч DVD/RW: Yes Утасгүй интернет/WiFi: Yes камер/Webcamera: Yes	Веб	2018	Ажлын 3 хоног	байхгүй	1
12	Принтер	Print Speed : Up to 21 ppm Print Resolution: Up to 1200 x 1200 dpi First Print Out Time: <8.5 seconds Duplex Printing: Manual Paper Input Capacity: 150 sheets Output Capacity: 100 sheets Processor 400 MHz Memory 64 MB Interface Hi-Speed USB 2.0 Weight: 3.97 Kg		2018	Ажлын 3 хоног	1 сар	1
13	Зурагт	Дэлгэц 49 инч Нягтрал Full HD 1920 x 1080 CEVO Engine дурсаулалттай 10 бит видео боловсруулалттай Дууны Технологи Dolby Digital, Dolby Digital Plus Дууны гаралт 10Вт+10Вт HDMI x 2 HDMI MHL USB 2.0 Тоон систем хүлээн авагч DVB-T2		2019	Ажлын 3 хоног	24 сар	11
14	Проектор	Технологи LCD Нягтаршил WXGA (1280x800) Лампны чадал / Eco 180W AC / 145W eco Лампны хугацаа / Eco 12.000цаг / 15.000цаг Гэрзлэлтэл 3300 ANSI lumens Линзний босоо шилжилт +/- 30 градус Ялгаралт 16.000:1 Тусах зайд 0.6 to 13.8m Утастай сүлжээ LAN Yes Оролт 1x RGB 2x HDMI 1x USB A 1x USB B LAN1x RCA 1x Mini Jack PC Control Жин 2.6kg Баталгаат хугацаа: 12 сар		2019	Ажлын 3 хоног	12 сар	1
15	Проектор	Технологи DLP Нягтаршил SXGA (800*600) Лампны чадал / Eco 180W AC / 145W eco Лампны хугацаа / Eco 4.000цаг / 5.000цаг Гэрзлэлтэл 3000 ANSI lumens Линзний босоо шилжилт +/- 30 градус Ялгаралт 3.000:1 Тусах зайд 0.6 to 13.8m Утастай сүлжээ LAN Yes Жин 2.6kg Баталгаат хугацаа: 12 сар		2019	Ажлын 3 хоног	12 сар	1
16	Угаалгын машин	Хуурай жингээрээ 10kg угаах хүчин чадалтай Star Crystal барабантай Угаах хүчин чадал 480Ватт Сэргээр хүчин чадал 520Ватт Усны түвшин 21-77 литр Шүүлтүүртэй /Cassette Lint Filter/ Эхлэх цагийг хойшлуулдаг Хүүхдээс хамгаалсан цоожтой		2019	Ажлын 3 хоног	12 сар	2
17	Угаалгын машин	Угаах жин хуурайгаар: 8,0kg , Сэргээр жин: 5,6kg, Дэвтээлтэй угаалт хийдэг Бохир усаа дараалтаар шахах помптой Хэмжээ нь: /өргөн, өндөр, гүн/ 80x95x48см		2018	Ажлын 3 хоног	12 сар	4

18	Тоос сорогч	1400 Ваттын хүчин чадалтай 400 Ваттын сорох хүчин чадалтай Тоосны багтаамж 4литр Цахилгааны залгуур 8 метр Жин 3,6	2018	Ажлын 3 хоног	12 сар	8
19	Ус цэвэршүүлэгч	Шинэ загварын цорго, халуун усны хамгаалах хэрэгсэл, ус нөөцлөх багтаамж, ус цэвэршүүлэх хүчин чадал нь цагт 30л, 3 шүүлтүүр бүхий 5 шатлалт шүүх системтэй.	2019	Ажлын 3 хоног	12 сар	6
20	Агаар цэвэршүүлэгч чийгшүүлэгч	Харшил үүсгэгч жижиг биетүүдийг 99.99% хүртэл үл нэвтрүүлэх цэвэршүүлнэ Бактерийн эсрэг фермент, ногоон цайны Catechin болон супер аллериги устгач хосолсон агаарын шүүлтүүртэй 26 м2 хүртэл өрөө, талбайн агаарыг цэвэршүүлэхэд тохиromхтой 350мл/цагт чийгшүүлэх боломжтой Өнгөт гэрэлэн индикатор нь өрөөний агаарын чанарыг харуулна Өрөөний чийгшэл мэдрэгчтэй Eco Mode нь цахилгаан хэмнэлттэй функцийтэй Автомат болон гар ажиллагааны функцийтэй Бохирдсон фильтерийг солих болсоныг мэдээлэх мэдээлэгчтэй Хүүхдээс хамгаалсан түгжээ 2.1 л хэмжээтэй усны савтай	2019	Ажлын 3 хоног	12 сар	2

НИЙТ

52

## Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

#### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарыт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарыт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарыт заавал оруулна.

#### Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

### **Магадлашгүй зардал**

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарыт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарыт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

**ҮНİЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны өрөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br><br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |

- |                                    |   |
|------------------------------------|---|
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b> | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br><br>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.<br><br><b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b> |
|                                    | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.   |

## В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- |   |  |
|---|--|
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>           | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарын тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.<br><br>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b> | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарын нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.  |
| <b>13. Алданги</b>                          | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги <sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.                                 |

## Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- |                         |   |
|-------------------------|---|
| <b>14. Ажил дуусгах</b> | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
| <b>15. Хүлээж авах</b>  | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.  |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.  
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.  
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүргэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>Баянзүрх дүүргийн 22 дугаар цэцэрлэгийн албан хэрэгцээнд шаарлагатай тоног тохөөрөмж нийлүүлэх ажил, БЗДХАА/201912070</b>
<b>ГЕН 2.1</b>	<p>Ажил нь <b>Баянзүрх дүүргийн 22 дугаар цэцэрлэгийн албан хэрэгцээнд шаарлагатай тоног тохөөрөмж нийлүүлэх ажил-аас бүрдэнэ.</b></p> <p>Ажлын талбай нь <b>Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо</b>-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.</p>
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <b>Гэрээ хийгдэх үед томилогдсон этгээд байна.</b>
<b>ГЕН 4.1</b>	<p>Ажил эхлэх өдөр <b>Гэрээнд заагдсан өдөр байна.</b></p> <p>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b>Гэрээнд заагдсан өдөр байна.</b></p>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>7</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <b>3 жилийн</b> байна.
<b>ГЕН 13.1</b>	<p>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>0,05/хувь</b>] байна.</p> <p>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>0,5 /хувь</b>] байна.</p>
<b>ГЕН 17.1</b>	<p>Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <b>14 хоног-ны</b> дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг <b>14 хоног -ны</b> дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <b>500,000/таван зуун мянга/төгрөг</b> байна.</p>
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <b>10 /хувь/-иар тооцно.</b>

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

### ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилщааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Унийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

**6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

**7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

**8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

**9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]